



ҮНЭТ ЦААС ГАРГАХ ТУХАЙ ГАРЫН АВЛАГА

ҮНЭТ ЦААС ГАРГАХЫН ДАВУУ ТАЛУУД

Санхүүжилтийн эх үүсвэр хангагдах

Компаниа өргөжүүлж хөгжүүлэх төслийг санхүүжүүлэх их хэмжээний эх үүсвэрийг бага зардлаар татан төвлөрүүлэхээс гадна ирээдүйд нэмэлт санхүүжилт татах ажиллагаа нь хялбаршиж зардал, цаг хугацааг хэмнэнэ

Компанийн засаглалын сайн тогтолцоо, чадварлаг боловсон хүчин, сайн менежментийн баг бүрдэх

Нээлттэй, ил тод, хяналттай болсноор компанийн засаглалын сайн тогтолцоо, сайн менежменттэй байх, чадварлаг хариуцлагатай удирдлагын баг бүрдэх боломжууд нээгдэнэ. Түүнчлэн, ажилтнуудад хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд илүү таатай нөхцөл бүрдүүлснээр чадвартай, шилдэг мэргэжилтнийг тогтвортой ажиллуулах боломж бүрдэнэ.

Зах зээлийн үнэлгээ нэмэгдэх

Компанийн үйл ажиллагаа, ирээдүйтэй холбогдох бүх мэдээллээс хамаарч компанийн үнэлгээ зах зээлийн ханшаар өндрөөр тогтоогдох боломжтой.

Олон нийт болон хөрөнгө оруулагчдад танигдах

Үнэт цаас гаргасан компаниуд нь хэвлэл мэдээллийн анхааралд илүү өртдөг төдийгүй зах зээлийн индексийн багцад орж тооцогдох боломжтой тул тухайн компани болон компанийн бүтээгдэхүүн, үйлчилгээг олон нийт таньж мэдэх боломжтой.

Мэргэжлийн хөрөнгө оруулагчдыг татах

Мэргэжлийн хөрөнгө оруулагчид үнэт цаасыг худалдан авснаар хувьцааны ханшийн хэлбэлзэл харьцангуй тогтворжих, хувьцаа эзэмшигчидтэй холбоотой зардлууд харьцангуй буурах, нэмэлт санхүүжилт татах ажиллагаа хялбарших боломжтой.

Цаг хугацаа, зардлыг хэмнэх

Үнэт цаасыг олон нийтэд санал болгохтой холбогдон гарах зардлууд, үүнд биржийн бүртгэлийн хураамжаас гадна зөвлөх байгууллагууд болох андеррайтерийн компани, хуулийн зөвлөх, аудитын компанийн төлбөр, маркетингийн зардал гэх мэт үндсэн зардлууд нь гадаадын зах зээлтэй харьцуулбал хямд тусахаас гадна орон зай, цаг хугацаанаас үүдэлтэй үйл явц удаашрах эрсдэлээс сэргийлнэ. Үнэт цаас гаргасны дараа хувьцаат компанийн үүргээ биелүүлэхэд ч илүү хялбар дөхөм байна.



МОНГОЛЫН
ХӨРӨНГИЙН БИРЖ

БҮРТГЭЛИЙН ШААРДЛАГА

01.

КОМПАНИ нь татварын болон хугацаа хэтэрсэн их хэмжээний зээлийн өргүй байх

02.

ХӨРӨНГӨ нь бүхэлдээ эсхүл дийлэнх нь мөнгө & богино хугацаат ҮЦ -наас бүрдээгүй байх

03.

Бүртгүүлэхээс өмнө **САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ХУГАЦААГАА** өөрчлөөгүй байх, өөрчилсөн бол тайланг аудитаар баталгаажуулсан байх

04.

ТУЗ -ИЙН ГИШҮҮД, ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГА & НӨЛӨӨ БҮХИЙ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД нь үнэнч шударга, ёс зүйтэй байх

05.

Холбогдох **ХУУЛЬ ТОГТООМЖ, ДҮРЭМ ЖУРАМ** & өөрийн **ЭРХ ЗҮЙН БАРИМТ БИЧГИЙГ** бүрэн дагаж мөрддөг байх

06.

ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНУУД нь компанийн үйл ажиллагааг явуулахад шаардлагатай мэдлэг, туршлагатай байх

07.

КОМПАНИЙН УДИРДЛАГА & ХЯНАЛТЫН БАГЦ ЭЗЭМШИГЧИД бүртгэгдсэнээс хойш 6 сарын хугацаанд хувьцаагаа худалдахгүй байх



ҮНЭТ ЦААСНЫ БҮРТГЭЛИЙН ШАЛГУУР

ХУВЬЦААНЫ ШАЛГУУР

ШАЛГУУР/АНГИЛАЛ	I АНГИЛАЛ	II АНГИЛАЛ	III АНГИЛАЛ
Үйл ажиллагаа явуулсан жил	тухайн чиглэлээр 3-аас доошгүй жил	тухайн чиглэлээр 2-оос доошгүй жил	
Санхүүгийн тайлан СТОУС	Сүүлийн 3 жил	Сүүлийн 2 жил	
Борлуулалтын орлого, ашиг төгрөгөөр	5 тэрбум эсхүл 1 тэрбумаас дээш цэвэр ашигтай байх	үйл ажиллагаа явуулах хангалттай хэмжээний ажлын капиталтай байх эсхүл 100 сая төгрөгөөс доошгүй хэмжээний ашигтай ажилласан байх	
Гүйцэтгэх удирдлагын багийн туршлага, хяналтын багц эзэмшигч	Сүүлийн 2 жилийн дотор компанийн гүйцэтгэх удирдлагын багийн бүрэлдэхүүний 2/3 хэмжээнд болон сүүлийн 1 жилд хувьцааны хяналтын багц эзэмшигчдийн бүтцэд томоохон өөрчлөлт ороогүй байх;		
Компанийн засаглал	Дотоодод болон олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн компанийн засаглалын зарчмыг дагаж мөрддөг байх;	Дотоодод болон олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн компанийн засаглалын зарчмыг дагаж мөрддөг байх, хэрэв мөрддөггүй бол тайлбар гаргах	Дотоодод болон олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн компанийн засаглалын зарчмыг дагаж мөрддөг байх, хэрэв мөрддөггүй бол тайлбар гаргах

Зах зээлийн үнэлгээ / төгрөгөөр	> 10 тэрбум	> 1 тэрбум	
Олон нийтэд эзэмшүүлэх хувь, арилжааны үнийн дүн	Нийт хувьцааны 25-аас доошгүй хувийг олон нийтэд санал болгосон байх ба цаашид бүртгэлтэй байх хугацаанд хэвээр хадгалагдах, эсхүл тухайн компанийн хувьцааны хагас жилийн арилжигдсан үнийн дүн нь Биржээр арилжаалагдсан хувьцааны нийт арилжааны үнийн дүнгийн 5-аас доошгүй хувь байх.	Үнэт цаас гаргагчийн Бирж дээр бүртгүүлэх нийт хувьцааны 25-аас доошгүй хувийг олон нийтэд санал болгосон байх ба цаашид бүртгэлтэй байх хугацаанд хэвээр хадгалах;	
Хувьцаа эзэмшигчдийн тоо	100-аас доошгүй байх ба цаашид бүртгэлтэй байх хугацаанд хэвээр хадгалагдах;	50-аас доошгүй байх ба цаашид бүртгэлтэй байх хугацаанд хэвээр хадгалах;	
Үнэт цаас нь арилжигдах боломжтой байх	барьцаалагдах зэргээр гуравдагч этгээдийн эрхээр хязгаарлагдаагүй, битүүмжлэгдээгүй, өмчлөх эрхийг шилжүүлэхэд аливаа хязгаарлалтгүй, чөлөөтэй шилжих, арилжигдах боломжтой байх.	барьцаалагдах зэргээр гуравдагч этгээдийн эрхээр хязгаарлагдаагүй, битүүмжлэгдээгүй, өмчлөх эрхийг шилжүүлэхэд аливаа хязгаарлалтгүй, чөлөөтэй шилжих, арилжигдах боломжтой байх.	барьцаалагдах зэргээр гуравдагч этгээдийн эрхээр хязгаарлагдаагүй, битүүмжлэгдээгүй, өмчлөх эрхийг шилжүүлэхэд аливаа хязгаарлалтгүй, чөлөөтэй шилжих, арилжигдах боломжтой байх.

УУЛ УУРХАЙН КОМПАНИУДАД ТАВИГДАХ НЭМЭЛТ ШАЛГУУР

I, II АНГИЛЛЫН УУЛ УУРХАЙН КОМПАНИУДАД ТАВИГДАХ НЭМЭЛТ ШАЛГУУР

	I АНГИЛАЛ	II АНГИЛАЛ
Ашигт малтмалын нөөцийн эзэмших	10-аас доошгүй жил	5-аас доошгүй жил
Ажлын капитал	Үйл ажиллагаагаа санхүүжүүлэхэд хангалттай байх	-
Хөрөнгийн бүтэц	30-аас доошгүй хувь нь өөрийн хөрөнгө байх	30-аас доошгүй хувь нь өөрийн хөрөнгө байх
Цэвэр биет хөрөнгө	5.0 тэрбумаас төгрөгөөс дээш	1.5 тэрбумаас төгрөгөөс дээш

III АНГИЛЛЫН УУЛ УУРХАЙН КОМПАНИУДАД ТАВИГДАХ НЭМЭЛТ ШАЛГУУР

	ХАЙГУУЛЫН ЛИЦЕНЗТЭЙ	АШИГЛАЛТЫН ЛИЦЕНЗТЭЙ
Үйл ажиллагаа явуулсан жил	2-оос доошгүй жил	-
Тусгай зөвшөөрөл	+	+
Ашигт малтмалын нөөцийн ашиглах эрх	Орд газрын 50-иас доошгүй хувь	10-аас доошгүй жил
Ажлын төлөвлөгөө /төгрөг/	500 саяас доошгүй	Арилжааны түвшинд авчрах
Ажлын капитал	Бүртгэгдсэнээс хойш 12 сарын хугацаанд хангалттай байх	Төлөвлөгдсөн хөрөнгө оруулалт болон үйлдвэрлэл явуулахад хүрэлцэх
Цэвэр биет хөрөнгө /төгрөг/	500 саяас доошгүй	1 тэрбумаас доошгүй
Мэргэшсэн мэргэжилтэн, шинжээч	5 - аас доошгүй жилийн холбогдох дадлага туршлагатай, дотоодын эсхүл олон улсын мэргэжлийн байгууллагад гишүүнчлэлтэй, хараат бус байх	

“-” шалгуур тавигдахгүй, “+” шалгуур тавигдана.

УУЛ УУРХАЙН КОМПАНИУД:

Ашигт малтмалын баялаг, ордын нөөц болон геологи-хайгуулын ажлын үр дүнгийн мэдээллийг:

- MRC code
- NI 43-101
- JORC code
- SAMREC code

Ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээний тайланг:

- MRC code
 - CIMVAL code
 - NI 43-101
 - SAMVAL code
 - VALMIN code
- аль нэгээр тус тус тайлагнана.

ӨРИЙН ХЭРЭГСЛИЙН ШАЛГУУР

Биржид өрийн хэрэгсэл бүртгүүлэхээр ӨРГӨДӨЛ ГАРГАГЧ нь хувьцааны бүртгэлийн II ангиллын шалгуураас гадна дараах шаардлагыг хангасан байна:

- Зээл, баталгаа, батлан даалтын гэрээгээр хүлээсэн хугацаа хэтэрсэн болон шүүхийн шийдвэрээр гүйцэтгэх өр төлбөргүй байх;
- Өмнө нь нийтэд санал болгон өрийн хэрэгсэл гаргасан бол хоёр болон түүнээс дээш удаа өрийн хэрэгслийн хүүгийн болон үндсэн төлбөрийг тогтсон хугацаанаас хоцроож, төлбөрийн тасалдал учруулж байгаагүй;

ӨРИЙН ХЭРЭГСЭЛ ГАРГАГЧ нь дээрх шалгуураас гадна дараах шалгуурын аль нэгийг хангасан байна:

- Үнэт цаас гаргагч нь үндсэн үйл ажиллагаагаа 3-аас доошгүй жил тасралтгүй эрхэлсэн байх ба өрийн хэрэгслийн үндсэн болон хүүгийн төлбөрийг бүрэн төлж чадах хангалттай хэмжээний барьцаа хөрөнгөтэй байх;
- Засгийн газраас бүхэлд нь баталгаа гаргасан, эсхүл Санхүүгийн зохицуулах хорооны “Компанийн өрийн хэрэгслийн бүртгэлийн журам”-ын 2.4-д заасан шаардлагыг хангасан байх;
- Дотоодын эсхүл олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн эрх бүхий байгууллагаар санхүүжих чадавхын зэрэглэл тогтоолгосон байх.

ӨРИЙН ХЭРЭГСЭЛ нь дараах шалгуурыг хангасан байна:

- Бүртгүүлэх үнэт цаас нь барьцаалагдах зэргээр гуравдагч этгээдийн эрхээр хязгаарлагдаагүй, битүүмжлэгдээгүй, өмчлөх эрхийг шилжүүлэхэд аливаа хязгаарлалтгүй, чөлөөтэй шилжих, арилжигдах боломжтой байх;
- Үнэт цаас гаргагчийн нийтэд санал болгон гаргах өрийн хэрэгслийн үнийн дүн нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 16.4-т заасан шаардлагыг хангасан байх;
- Хувьцаанд хөрвөх өрийн хэрэгслийн хувьд хөрвөх хувьцааны тоо нь компанийн нийт гаргасан хувьцааны 30 хувиас хэтрэхгүй байх, Биржээс тогтоосон олон нийтийн эзэмшлийн хувь хэмжээний шаардлагыг хангаж байх;
- Хөрвөх өрийн хэрэгслийн хувьд хөрвөх хувьцаа нь Биржид бүртгэлтэй байх ба Монгол Улсын Компанийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасан нөхцөл, шаардлагыг хангасан байна;
- Ногоон бонд болон бонд гаргах хөтөлбөрийн хувьд Санхүүгийн зохицуулах хорооны “Компанийн өрийн хэрэгслийн бүртгэлийн журам”-д заасан нөхцөл шаардлагыг хангасан байна;
- Өрийн хэрэгсэл худалдан авагчдын эрх ашигт сөргөөр нөлөөлөх, тэдэнд эрсдэл учрах магадлалтай гэж үзвэл эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхийг барьцаагаар баталгаажуулахыг, эсхүл гуравдагч хөндлөнгийн этгээдээр баталгаа гаргуулахыг тус тус шаардаж болно;
- Өрийн хэрэгслийн үүргийн гүйцэтгэлийг хангах барьцаа, баталгаа, батлан даалт нь Иргэний тухай хууль болон Санхүүгийн зохицуулах хорооны “Компанийн өрийн хэрэгслийн бүртгэлийн журам”-д заасан шаардлагыг хангасан байна.

ТОГТМОЛ БИЕЛҮҮЛЭХ ҮҮРЭГ



**БҮРТГҮҮЛСЭН АНГИЛЛЫН
ШАЛГУУРЫГ ХАНГАЖ
АЖИЛЛАНА**



ХЭХ, НОГДОЛ АШИГ
хуваарилахдаа хууль, дүрэм
журмыг баримтална



**КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН
КОДЕКСИЙГ** дагаж мөрдөх



Үйл ажиллагааны болон хөрөнгө
оруулалтын шийдвэр гаргахад
шаардлагатай мэдээллийг **ТОГТМОЛ**
болон **ТУХАЙ БҮР МЭДЭЭЛЭХ**



Санхүүгийн тайланг **СТОУС**-д
нийцүүлэн гаргаж, аудитын
байгууллагаар тогтмол
баталгаажуулан Хороо болон
Биржид ирүүлнэ



Биржтэй байгуулсан
бүртгэлийн гэрээнд заасан
ҮҮРГЭЭ БИЕЛҮҮЛНЭ

БҮРТГЭЛИЙН ШАЛГУУРААС ЧӨЛӨӨЛӨХ

I, II АНГИЛЛЫН ШАЛГУУРААС ЧӨЛӨӨЛӨГДӨХ БОЛОМЖТОЙ ҮНЭТ ЦААС ГАРГАГЧ:



Гадаад улсын арилжаа эрхлэх
байгууллагад бүртгэлтэй,
ХОЁРДОГЧ БҮРТГЭЛ ХИЙЛГЭХ



Улсын болон бүс нутгийн
хөгжилд өндөр ач холбогдол
бүхий **“ДЭД БҮТЦИЙН ТӨСӨЛ”**
хэрэгжүүлэх



**ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН
СОНИРХЛЫГ ИХЭЭР ТАТАЖ,
ЭРЭЛТ ҮҮСГЭЖ БУЙ**




НҮБ-ээс тогтоосон **ТОГТВОРТОЙ
ХӨГЖЛИЙН 17 ЗОРИЛТОД
ЧИГЛЭСЭН** үйл ажиллагаатай



Монгол Улсын **“НОГООН ТАКСОНОМИ”**, эсхүл олон
улсын холбогдох стандарт, шалгуурт заасан ангилал,
шалгуурын дагуу **“НОГООН”, “БАЙГАЛЬ ОРЧИНД
ЭЭЛТЭЙ”** үйл ажиллагааг санхүүжүүлэх тохиолдол.

ҮНЭТ ЦААС ГАРГАХ ҮЕ ШАТ



ҮНЭТ ЦААС ГАРГАСАН КОМПАНИУДЫН СТАТИСТИК

ХУВЬЦАА ГАРГАН ХӨРӨНГӨ ТАТАН ТӨВЛӨРҮҮЛСЭН КОМПАНИУДЫН СУДАЛГАА

КОМПАНИЙН НЭР	ТАТАН ТӨВЛӨРҮҮЛСЭН ХӨРӨНГӨ /тэрбум төгрөг/
"Хаан Банк" ХК	183.38
"Голомт Банк" ХК	118.81
"Худалдаа хөгжлийн банк" ХК	83.49
"Мик холдинг" ХК	37.27
"Хас банк" ХК	35.67
"Богд Банк" ХК	31.75
"Төрийн Банк" ХК	25.42
"Премиум Нэксус" ХК	24.95
"Инвескор ББСБ" ХК	18.58
"Эм жи эл акуа" ХК	15.23
"Монголын хөрөнгийн бирж" ХК	11.91
"Монложистикс Холдинг" ХК	10.98
"Газар шим үйлдвэр" ХК	10.50
"Сэндли ББСБ" ХК	10.05
"Түмэн шувуут" ХК	10.00
"Монос Хүнс" ХК	8.58
"Женко тур бюро" ХК	8.26
"Мандал даатгал" ХК	7.5

КОМПАНИЙН НЭР	ТАТАН ТӨВЛӨРҮҮЛСЭН ХӨРӨНГӨ /тэрбум төгрөг/
"Монгол базальт" ХК	6.43
"Тэнгэр даатгал" ХК	6.0
"Бодь Даатгал" ХК	5.32
"Ард Кредит ББСБ" ХК	5.28
"Ард даатгал" ХК	5.25
"Ремикон" ХК	5.05
"Лэндмн ББСБ" ХК	5.0
"Хөх ган" ХК	3.20
"Мон бийф" ХК	2.89
"Мерекс" ХК	2.6
"Хөх ган" ХК	3.20
"Мон бийф" ХК	2.89
"Мерекс" ХК	2.6
"Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн" ХК	2.49
"Гермес центр" ХК	2.36
Айтүүлс ХК	1.34
"Инновэйшн Инвестмент" ХК	0.9

ХӨРӨНГӨӨР БАТАЛГААЖСАН ҮНЭТ ЦААС ГАРГАН ХӨРӨНГӨ ТАТАН ТӨВЛӨРҮҮЛСЭН КОМПАНИУДЫН СУДАЛГАА

КОМПАНИЙН НЭР	ТАТАН ТӨВЛӨРҮҮЛСЭН ХӨРӨНГӨ /тэрбум төгрөг/
"Инвекор Эй Би Эс ТЗК" ХХК - Инвекор ХБҮЦ	50.0
"Бичил Эй Би Эс Плас ТЗК" ХХК - Бичил-2 ХБҮЦ	20.0
"Бичил Эй Би Эс Лояалти ТЗК" ХХК - Бичил-3 ХБҮЦ	20.0
"Бэрс Эй Би Эс Лояалти ТЗК" ХХК - Бэрс-3 ХБҮЦ	15.0
"Омни Ассет ТЗК" ХХК - Омни Ассет ХБҮЦ	6.0

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН НЭГЖ ЭРХ ГАРГАН ХӨРӨНГӨ ТАТАН ТӨВЛӨРҮҮЛСЭН КОМПАНИУДЫН СУДАЛГАА

САНГИЙН НЭР	ТАТАН ТӨВЛӨРҮҮЛСЭН ХӨРӨНГӨ /тэрбум төгрөг/
Мандал Ирээдүйн Өсөлт	50.0
Үндэсний хувьчлалын сан	5.0

КОМПАНИЙН БОНД ГАРГАН ХӨРӨНГӨ ТАТАН ТӨВЛӨРҮҮЛСЭН КОМПАНИУДЫН СУДАЛГАА

КОМПАНИЙН НЭР	ТАТАН ТӨВЛӨРҮҮЛСЭН ХӨРӨНГӨ /тэрбум төгрөг/
Эрдэнэс таван толгой Хаалттай ХК	692.53
Инвекор ББСБ ХК	20.00
ЛэндМН ББСБ ХК	15.60
Сүү ХК	6.00
Барилга корпораци ХК	5.34
Жаст агро ХХК	4.39
MCS Электроникс ХХК	1.48
Их барилга төсөл ХХК	1.30
Нийслэл өргөө ХК	1.20
Алтан хот корпораци ХХК	1.00
Говь ХК	1.00
Пума групп	1.00
Мобифинанс ББСБ ХХК	1.00
Монинжбар ХК	0.50
Монинжбар ХК	0.50
Эрчим инженеринг	0.46
Анод банк	0.21
Монфреш жүүс ХХК	0.18

АНДЕРРАЙТЕРИЙН КОМПАНИУДЫН ХАЯГ



КОМПАНИУДЫН НЭР	ХАЯГ	УТАСНЫ ДУГААР
"Эс жи инвестмент энд секьюритис ҮЦК" ХХК	Улаанбаатар Хан-Уул 15-р хороо Богд Жавзандамба 18-р хороо 803А	7570-3131
"Стоклаб секьюритиз ҮЦК" ХХК	Улаанбаатар Чингэлтэй 1-р хороо Бизнес 34 центр А корпус 01 тоот	77991177
"Райнос инвестмент ҮЦК" ХХК	Улаанбаатар Сүхбаатар 8-р хороо Сүхбаатарын талбай Сентрал тауэр 13 давхар, 1308Б тоот	75100575
"Инвескор капитал ҮЦК" ХХК	Улаанбаатар Сүхбаатар 1-р хороо Парисын гудамж Ай Си Тауэр барилга 15 давхар	77550077,
"Голомт капитал ҮЦК" ХХК	Улаанбаатар Сүхбаатар 1-р хороо Чингисийн өргөн чөлөө Парк Плэйс оффис 403-404	70121530
"Таван богд капитал ҮЦК" ХХК	Улаанбаатар Сүхбаатар 8-р хороо Их эзэн Чингис хааны нэрэмжит талбай-16 Галлери-а-Улаанбаатар худалдаа үйлчилгээний төв 1 давхар	72727282
"Мазаалай капитал партнерс ҮЦК" ХХК	Улаанбаатар Сүхбаатар 8-р хороо Б.Алтангэрэлийн гудамж, Сити центр 7 давхар, 701 тоот	99085136
"Стандарт инвестмент ҮЦК" ХХК	Улаанбаатар Сүхбаатар 6-р хороо Бага тойруу 73/8 53 тоот	70114433
Мирэ эссэт сэкьюритис Монгол ҮЦК" ХХК	Улаанбаатар Баянгол 1-р хороо Энхтайвны өргөн чөлөө blue sky 406	70110806,
"Нэйшнл сэкьюритис ҮЦК" ХХК	Улаанбаатар Сүхбаатар 8-р хороо Велокс центр 5 давхар 503 тоот	77097070
"Апекс капитал ҮЦК" ХХК	Улаанбаатар Сүхбаатар 1-р хороо Олимпийн гудамж- 4 Нью хоризонс 901	75107500

КОМПАНИУДЫН НЭР	ХАЯГ	УТАСНЫ ДУГААР
"Ти ди би секьюритис ҮЦК" ХХК	Улаанбаатар Сүхбаатар 1-р хороо Энхтайвны өргөн чөлөө 19 Худалдаа хөгжлийн байр 609	70100261
"Новел инвестмент ҮЦК" ХХК	Улаанбаатар Чингэлтэй 6-р хороо Их тойруу-49 Өег тулга ХХК-ийн байр 304 тоот	70121616,
"Эс жи капитал ҮЦК" ХХК	Улаанбаатар Сүхбаатар 1-р хороо Жамьян гүний (Меру тауэр) 10 давхар 1002 тоот	99010166
"Гүүдсек ҮЦК" ХХК	Улаанбаатар Сүхбаатар 2-р хороо сөүл 10/1 дугаартай барилга 1501 тоот	11-331878
"Мандал капитал маркетс ҮЦК" ХХК	Улаанбаатар Сүхбаатар 1-р хороо 1 Мэру тауэр 601	75753399
"Өлзий энд КО капитал ҮЦК" ХХК	Улаанбаатар Сүхбаатар 8-р хороо Сити Тауэр, 2506	7777-6377
"Лайфтайм инвестмент ҮЦК" ХХК	Улаанбаатар Сүхбаатар 3-р хороо Сөүл гудамж Брау Хаус центр 310Б	70121418
"Тэнгэр капитал ҮЦК" ХХК	Улаанбаатар Сүхбаатар 1-р хороо Жамьян гүний гудамж Меру тауэр 10 давхар 1003	70110637
"Тэнгэр капитал ҮЦК" ХХК	Улаанбаатар Сүхбаатар 1-р хороо Жамьян гүний гудамж Меру тауэр 10 давхар 1003	70110637
"Тэнгэр капитал ҮЦК" ХХК	Улаанбаатар Сүхбаатар 1-р хороо Жамьян гүний гудамж Меру тауэр 10 давхар 1003	70110637
"Тэнгэр капитал ҮЦК" ХХК	Улаанбаатар Сүхбаатар 1-р хороо Жамьян гүний гудамж Меру тауэр 10 давхар 1003	70110637
"Тэнгэр капитал ҮЦК" ХХК	Улаанбаатар Сүхбаатар 1-р хороо Жамьян гүний гудамж Меру тауэр 10 давхар 1003	70110637



“Монголын хөрөнгийн бирж” ХК
Сүхбаатарын талбай-3, Улаанбаатар 15160, Монгол улс
+976-11-313747 | info@mse.mn | www.mse.mn